



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/152

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2022 оны 02-р тогтоол (Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам)-ын 3.6.5 дэх заалт, сумын ИТХ-ын 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 03 дугаар хуралдааны А/19 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Зэрлэг ан амьтан, цагаан зээрийг хамгаалах ажлыг сурталчлах, хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулахад шаардагдах 1.000.000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг байгалийн нөөц ашигласан орлогоос зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН